## 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэзс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Харилцагчтай байгуулсан гэрээний дагуу HOSPITAL цахим системийн үйлчилгээний 2025 оны 6 дугаар сар хүртэлх хугацааны төлбөрт 6,600,000.0 төгрөг төлөөд урьдчилж төлсөн зардлаар бүртгэлгүй, тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч буруу бүртгэсэн. | 1 | 6,600.0 | - | - | 1 | 6,600.0 | 1 | 6,600.0 | - | - | - | - |
| Харилцагчтай байгуулсан гэрээний дагуу 2025, 2026, 2027 онуудын Менежментийн баталгаажуулалтын хяналтын төлбөрт 4,125,000 төгрөг төлөөд урьдчилж | 1 | 4,125.0 | - | - | 1 | 4,125.0 | 1 | 4,125.0 | - | - | - | - |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| төлсөн зардлаар бүртгэлгүй, тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч буруу бүртгэсэн. | | | | | | | | | | | | |
| 2025.12,27-ны өдөр хүртэлх Тээврийн хэрэгслийн даатгалд 546,920 төгрөгийг шилжүүлж, урьдчилж төлсөн зардлаар бүртгэлгүй, тайлан үеийн зардлаар хүлээн зөвшөөрч буруу бүртгэсэн. | 1 | 546.9 | - | - | 1 | 546.9 | 1 | 546.9 | - | - | - | - |
| Тайлант оны цалингийн хүн амын орлогын албан татварын суутгалын тооцооллыг буруу тооцсноос 3,504,300.0 төгрөгийн татварын авлага дутуу бүртгэсэн байна. | 1 | 3,504.3 | 1 | 3,504.3 | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **4** | **14,776.2** | **1** | **3,504.3** | **3** | **11,271.3** | **3** | **11,271.3** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 заасан бүрэлдэхүүний дагуу гаргаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Нэр бүхий ажилтанд гадаадад сургалтанд хамрагдахад 1,221,700 төгрөгийг олгосон нь байгууллагын даргын тушаал шийдвэргүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. | 1 | 1,221.7 | - | - | - | - | 1 | 1,221.7 | - | - | - | - |
| Харилцагч байгууллагад гэрээний дагуу Чанарын гадаад хяналтын төлбөрт 6,500,000 төгрөгийг шилжүүлсэн, гэрээг дүгнэн акт үйлдээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу | 1 | 6,500.0 | - | - | - | - | 1 | 6,500.0 | - | - | - | - |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| байхад зардалд бүртгэж тайлагнасан | | | | | | | | | | | | |
| Хувь хүнээс худалдаж авсан (нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар) 150,600 төгрөгийн бичиг хэргийн материалыг орлогд аваагүй шууд зардал бүртгэсэн. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 50,998,152.61 төгрөгийн 15 ширхэг хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, шинэчлэн тогтоох үнийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Тайлант онд 14,311,000 төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 14,311.0 | - | - | 1 | 14,331.0 | - | - | - | - | - | - |
| Тайлант хугацаанд 92,338,975.00 төгрөгийн бараа материалын зардлагын гүйлгээг бүртгэхдээ шаардах хуудсанд байгууллагын дарга зөвшөөрч гарын үсэг зурдаггүй, шаардах хуудас дээр бичигдсэн тоо засвартай, зарим бараа материалын зарлагын | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| шаардах хуудас бичээгүй, зөвхөн зарлагын баримт хөтөлсөн зэрэг бүртгэлээр тавих хяналт сул байна. | | | | | | | | | | | | |
| Үндсэн үйл ажиллагааны орлогыг анх 550,000,000.0 төгрөгөөр төлөвлөж, тодотголоор 47.2 хувь буюу 260,000,000.0 төгрөгөөр нэмэгдүүлэн 810,000,000.0 төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 1,386,664,200.0 төгрөгийн орлого орсон нь төлөвлөгөөг 58.4 хувиар буюу 576,664,200.0 төгрөгөөр давж биелүүлсэн байна. Давсан орлогоос 2024 онд 429,841,300.0 төгрөг буюу 74.5 хувийг Сангийн сайдын 2024 оны 224 дугаар тушаалаар зарцуулах эрх олгосны дагуу ажилчид урамшуулал олгох болон бусад зүйлд зарцуулсан байна. Орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөхгүй, давсан орлого бүрдүүлж зарцуулж байгаа нь төсвийн хэмнэлтийн талаар хэрэгжүүлж байгаа бодлого чиглэлтэй нийцэхгүй байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тайлант онд 48,676,000.0 мянган төгрөгийн слайд хадгалах шүүгээ болон 44,550,000.0 мянган төгрөгийн процессор, өнгөт принтер, сервер компьютерийг тус тус сонгон шалгаруулалтгүй шууд худалдан авсан. | 1 | 93,226.0 | - | - | 1 | 93,226.0 | - | - | - | - | - | - |
| Тайлант онд ажилчдад олгосон урамшууллаас 28,927,400 төгрөгийн НД, ЭМД-ын шимтгэлийг суутгаагүй байна. (Нийгмийн даатгалын тайланг нөхөн гарган тайлагнаж, шимтгэлийг төлөх ) | 1 | 28,927.4 | 1 | 28,927.4 | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **10** | **144,186.1** | **1** | **28,927.4** | **4** | **107,557.0** | **5** | **7,701.7** | - | - | - | - |







**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн ау...**

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд шинэчлэгдсэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шилэн дансанд мэдээллээгүй байна, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,262,096,500.0 төгрөгийн 17 гүйлгээ, зарлагын 474,148,600.0 төгрөгийн 4 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн. | 1 | 474,148.6 | - | - | - | - | 1 | 474,148.6 |
| **Дүн** | **1** | **474,148.6** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **474,148.6** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант хугацаанд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй Шинэ хоршоо төслийн хүрээнд 2 ажилтанд орон нутагт ажиллах томилолтын зардалд 4,395,000.0 төгрөгийг олгож, томилолтын зардалд бүртгэн тайлагнасан, томилолтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. | 1 | 4,395.0 | - | - | - | - | 1 | 4,395.0 |
| **Дүн** | **1** | **4,395.0** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **4,395.0** |
| **Нийт дүн** | **2** | **478,543.6** | **-** | **-** | **-** | **-** | **2** | **478,543.6** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ
01

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2025 оны 07 дугаар сарын 25 № 26/А0150185 Улаанбаатар хот

СНАГ-2025/017/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд ажилчдад олгосон урамшууллаас 28,927,400.00 */хорин найман сая есөн зуун хорин долоон мянга дөрвөн зуун/* төгрөгийн Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суутгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна" 19.1.3-т "ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилчдад олгосон урамшууллаас Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суутгаж, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын 100200690000 тоот дансанд төвлөрүүлэн, нийгмийн даатгалын нөхөн тайлан гаргаж, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч / Б.Ганзориг/, ерөнхий нягтлан бодогч / Н.Батбаяр / нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264130

Z:\Akt\2025\0224 SNAG-14.Docx

0001090700

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр | Дугаар 84/А0150185 СНАГ-2025/017/НА-СТА-ТШ3 | Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд 48,676,000.00 */дөчин найман сая зургаан зуун далан зургаан мянган/* төгрөгийн слайд хадгалах шүүгээ болон 44,550,000.00 */дөчин дөрвөн сая таван зуун тавин мянган/* төгрөгийн процессор, өнгөт принтер, сервер, компьютер зэргийг бэлтгэхдээ сонгон шалгаруулалтгүй, шууд худалдан авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах босго баримтлаагүй, харьцуулалтын аргаас зайлсхийж, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч / Б.Ганзориг/, ерөнхий нягтлан бодогч /Н.Батбаяр/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — В.ЭРДЭНЭЦОГТ
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ — Д.ЭХБАЯР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

*E:\Alban Shaardlaga\2025\0224 SNAG-23.Docx*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 85/А0150185 СНАГ-2025/017/НА-СТА-ТШ3 Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг анх 550,000,000.00 /таван зуун тавин сая/ төгрөгөөр төлөвлөж, тодотголоор 47.2 хувь буюу 260,000,000.00 /хоёр зуун жаран сая/ төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 1,386,664,200,00 /нэг тэрбум гурван зуун наян зургаан сая зургаан зуун жаран дөрвөн мянга хоёр зуун/ төгрөгийн орлого орж төлөвлөгөө 58.4 хувиар буюу 576,664,200.00 /таван зуун далан зургаан сая зургаан зуун жаран дөрвөн мянга хоёр зуун/ төгрөгөөр илүү бүрдүүлжээ. Сангийн сайдын 2024 оны 224 дугаар тушаалаар давсан орлогоос зарцуулах эрх олгосны дагуу 429,841,300.00 /дөрвөн зуун хорин есөн сая найман зуун дөчин нэгэн мянга гурван зуун/ төгрөг буюу 74.5 хувийг ажилчдад урамшуулал олгох болон бусад зүйлд зарцуулсан байна. Орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүйгээс, давсан орлого бүрдүүлж, зарцуулж байгаа нь төсвийн хэмнэлтийн талаар хэрэгжүүлж байгаа бодлого чиглэлтэй нийцэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орлогын төлөвлөгөө бодитой төлөвлөөгүйгээс давсан орлого бүрдүүлж, зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч / Б.Ганзориг/, ерөнхий нягтлан бодогч / Н.Батбаяр / нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 86/А0150185 СНАГ-2025/017/НА-СТА-ТШ3 Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант хугацаанд 92,338,975.00 /ерэн хоёр сая гурван зуун гучин найман мянга есөн зуун далан таван/ төгрөгийн бараа материалын зарлагын гүйлгээг бүртгэхдээ шаардах хуудсанд байгууллагын дарга зөвшөөрч гарын үсэг зурдаггүй, шаардах хуудас дээр бичигдсэн too засвартай, зарим бараа материалын зарлагын шаардах хуудас бичээгүй, зөвхөн зарлагын баримт хөтөлсөн зэрэг бүртгэлээр тавих хяналт сул байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын зарлагын анхан шатны баримтад /шаардах хуудас/ зөвшөөрсөн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажаагүй, тоо мэдээлэл засвартай зэрэг анхан шатны хүчин төгөлдөр бус, бүрэн баталгаажаагүй баримтаар гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэл тайланд тусгасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч / Б.Ганзориг /, ерөнхий нягтлан бодогч / Н.Батбаяр / нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 87/А0150185 СНАГ-2025/017/НА-СТА-ТШЗ Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд 14,311,000.00 */арван дөрвөн сая гурван зуун арван нэгэн мянган/* төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 42 дугаар зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч / Б.Ганзориг /, ерөнхий нягтлан бодогч / Н.Батбаяр / нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**
САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ЭХБАЯР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*